

Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргааны

11-р сарын мэдээ


Хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт


Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд Хархорин сумын ТХГНутаг болох Орхон, Нарийн хүр багт амьдарч байгаа айл өрхүүдэд хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор санамж бэлтгэн тарааж, мэдээлэл түгээж, хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллаа.

Хархорин сум хариуцсан байгаль хамгаалагч Ш.Мөнхсайхан Нарийн хүр багийн дарга Пүрэвдоржтой хамтран ТХГН болох Нарийн хүр багийн Баянголын ам, Тэмээн хүзүү, Бага саруул, Буд, Лондон, Хавцал, Гүвдээ, Таван лам, Баруун намаг, Адгийн согоот зэрэг газар нутгаар нийт 21 өрхийн 47 иргэнд хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор брошур тараан ухуулга сурталчилгаа хийлээ.



Хамгаалалтын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу 2016 оны 11-р сарын 14-16 хооронд Бат-Өлзий сумын Бөөрөг хариуцсан байгаль хамгаалагч Х.Чулуунбат, Цутгалан хариуцсан байгаль хамгаалагч М.Мөнхдалай, Могойт хариуцсан байгаль хамгаалагч Ш.Баасансүрэн, Хужирт сумын Үүртийн тохой хариуцсан байгаль хамгаалагч, байцаагч Б.Даш нар бүрэлдэхүүнээрээ ТХГН-т амьдарч байгаа 32 өрхийн 91 иргэнд хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ухуулга сурталчилгаа хийж 50 ширхэг санамж тараан ажиллаа.





Мөн Нарийн хүр багийн иргэн Н.Энхбат, Баттулга нар ТХГН-аас зохих зөвшөөрөлгүй унанги хаягдал авч малын саравч барьсанд Бат-Өлзий сумын сум дундын ойн ангид экологи эдийн засгийн үнэлгээг гаргуулахаар холбогдох материалыг хүргүүлээд байна.

Хархорин сумын иргэн Л.Түмэнхүү нь Архангай аймгийн Хотонт сумаас гарал үүслийн гэрчилгээгүй түлээний мод тээвэрлэсэнд 960000 төгрөгийн торгууль ногдуулж, захиргааны арга хэмжээ авч Хархорин сумын ЗД-ын дэргэдэх захиргааны зөвлөлд 1,8м³ модыг хүлээлгэн өглөө.



БОАЖЯамны 10/1745 тоотыг үндэслэн Орхоны хөндийн ТХГН-т шинээр газар ашиглах иргэн, аан-үүдийн хүсэлтийг түр зогсоогоод байна.

Орхоны хөндийн БЦГ-ын байгаль хамгаалагч, байцаагч нар Хүрмэн чулуу нөхөрлөлийн гишүүдтэй хамтран Хүрхрээ орчмын хог хаягдалыг цэвэрлэлээ.

Мэдээлэл, сургалт, сурталчилгаа

2016 оны 11 дүгээр сар 14-19 өдрүүдэд Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын СТЕП төслийн санхүүжилтээр мэргэжилтэн Ч.Суурьтогтох Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ сургалтанд хамрагдаж сургагч багшийн гэрчилгээ авлаа..



Ерөнхий боловсролын сургуулийн 8-р ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ Байгаль, соёлын өвөө хамгаалахад хүүхдийн оролцоо” сэдэвт АСК тэмцээнийг харьяа 6 сумын сургуулиудын дунд зохион байгууллаа.



Тэмцээнд 6 баг авхаалж самбаа, авьяас мэдлэгээ сорин өрсөлдсөнөөс Хархорин сумын МГСС-ын 8а бүлэг Тэргүүн байр, Батөлзий сумын 8б бүлэг Дэд байр, Хужирт сумын 2-р сургуулийн 8б бүлэг Гуравдугаар байр эзэллээ.

Байгууллагын 2016 оны үр дүнгийн гэрээний илтгэх хуудас, тайлангийн хамт ТХНУГ-т хугацаанд нь хийж цахим болон цаасар хүргүүлэв.

Орчны бүсийн нөхөрлөлийн судалгааг гаргаж ТХНУГ-ын мэргэжилтэнд цахим хаягаар хүргүүлэв.

БОАЖСайдын ажлын албанаас өгсөн үүрэг даалгаварын дагуу БНСУ-ын ТХГН-тай эгч дүүсийн холбоо байгуулах ажлын хүрээнд ОХБЦГ-ын танилцуулга, мэдээлэл, гэрээний төслийг англи, монгол хэлээр хийж бэлтгэн ТХНУГ-ын мэргэжилтэн С.Мөнх-Оргилд цахимаар хүргүүлээд байна.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох.